



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/НЗ

Арвайхээр

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх  
арга хэмжээний төлөвлөгөө, зардлын  
хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, “Журам шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоол, “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07/08 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2022 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө, зардлын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулах 562,000,000 (таван зуун жаран хоёр сая) төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

3.Гүйцэтгэл, үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0091

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2022 оны  
 01 дүгээр сарын 31-ны өдрийн  
 444 дугаар захирамжийн  
 хавсралт

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга  
 хэмжээний төлөвлөгөө, зардлын хуваарь

| д/д   | Хэрэгжүүлэх арга хэмжээ   | Зардал<br>(сая төг) | Хугацаа            | Хариуцагч                 |
|---|---|---------------------|--------------------|---------------------------|
| <b>1.Нөхөн сэргээх зардлаар</b>                     |   |                     |                    |                           |
| 1   | “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод үржүүлгийн газруудын чадавхыг бэхжүүлэх, тарьц суулгац худалдан авах сонгон шалгаруулалт зохион байгуулах                       | 200.0               | Жилдээ             | Ю.Ганхуяг                 |
| 2   | Ойн санд ойн хөнөөлт шавжтай тэмцэх хортон устгалын ажил гүйцэтгэх /2000 га/  | 86.0                | Жилдээ             | Ю.Ганхуяг                 |
| 3   | Мод тарих газрын хамгаалалтын хайс, хашаа барих   | 75.6                | Жилдээ             | Ю.Ганхуяг                 |
| 4   | Хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөрсөнд үл нэвчих “Эко” ариун цэврийн байгууламж байршуулах  | 38.0                | Жилдээ             | Г.Цэвэлмаа<br>М.Мөнхсүрэн |
| <b>Дүн</b>  |   | <b>399.6</b>        |                    |                           |
| <b>2.Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар:</b> |   |                     |                    |                           |
| 1   | “Тэрбум” мод хөдөлгөөний хүрээнд төв суурин газрын нийтийн эзэмшлийн талбайд тарих модны тарьц, суулгац худалдан авч сумдад нийлүүлэх   | 60.0                | Жилдээ             | Ю.Ганхуяг                 |
| 2   | Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх   | 16.0                | Жилдээ             | Ю.Ганхуяг                 |
| 3   | Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, зөвлөгөөн, туршлага судлах ажил зохион байгуулах | 20.0                | Жилдээ             | Ц.Батгэрэл                |
| 4   | Нэн ховор, ховор амьтдад зориулж биотехникийн арга хэмжээ авах  | 5.0                 | 1,4 дүгээр улиралд | Ц.Батгэрэл                |
| 5   | Шаардлагатай газарт хөв цөөрөм байгуулах зураг төсөв хийлгэх  | 12.0                | Жилдээ             | Б.Энхсүрэн                |
| 6   | Булаг шанд, рашааны эхийг хамгаалах   | 14.0                | Жилдээ             | Б.Энхсүрэн                |
| 7   | Орон нутгийн чанартай, бүрэн судлагдаагүй рашааны чанар найрлагыг тодорхойлох судалгаа хийлгэх, тооллого зохион байгуулах   | 15.0                | Жилдээ             | Б.Энхсүрэн                |
| 8   | Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумын усны сан бүхий газарт хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэх  | 2.0                 | Жилдээ             | Б.Энхсүрэн                |
| 9   | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн зохион байгуулах тухай Ерөнхийлөгчийн зарлиг,   | 8.0                 | Жилдээ             | Мэргэжилтнүүд             |

|    |  |              |        |           |
|----|--|--------------|--------|-----------|
|    | байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажил   |              |        |           |
| 10 | Шаардлагатай сумдад идэвхтэн байгаль хамгаалагч улирлын чанартай ажиллуулах, ажлын үр дүнгээр урамшуулах, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, | 10.4         | Жилдээ | Э.Золзаяа |
|    | <b>Дүн</b>   | <b>162.4</b> |        |           |